



# “БИЧИЛ ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346, info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Ц.Азбаяр /"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



## Агуулга

---

1. ХБҮЦ-ны мэдээлэл .....	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл .....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл .....	5
4. Хавсралт - Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт .....	6

## 1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бичил Глобус Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Ц.Азбаяр, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Баасандорж, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Отгонбат нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 10 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

### Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011840095
Регистрийн дугаар	6875351
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/11/09
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	607
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	100,000
ХБҮЦ (сая төг.)	10,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.5%
ХБҮЦ-ны үндсэн төлбөр төлөх давтамж	Хагас жил тутам
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал тутам
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

"Бичил Эй Би Эс Актив ТЗК" ХХК нь ХБҮЦ-ны төлбөрийг Хүснэгт 2-т харуулсан хуваарийн дагуу төлнө.

### Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/03/20	10,000,000,000.00	-	436,301,369.86
2	2023/06/19	10,000,000,000.00	2,500,000,000.00	436,301,369.86
3	2023/09/19	7,500,000,000.00	-	330,821,917.81
4	2023/12/19	7,500,000,000.00	2,500,000,000.00	327,226,027.40
5	2024/03/19	5,000,000,000.00	-	218,150,684.93
6	2024/06/19	5,000,000,000.00	2,500,000,000.00	220,547,945.21
7	2024/09/19	2,500,000,000.00	-	110,273,972.60
8	2024/12/19	2,500,000,000.00	2,500,000,000.00	109,075,342.47
Нийт			10,000,000,000.00	2,188,698,630.14

## 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 3.4 хувиар буурсан байна.

### Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.19	2022.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	10,000,069,105.84	9,659,997,745.64	-3.4%
Зээлийн дундаж үлдэгдэл	10,482,252.73	10,276,593.35	-2.0%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.50%	0.50%	0.8%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	3.47%	3.55%	2.5%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	33.97%	33.97%	0.0%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	48.32%	47.55%	-1.6%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	12.71	13.13	3.3%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	24.31	23.94	-1.5%
Сарын дундаж төлбөрийн дүн	785,920.57	783,638.03	-0.3%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	5,498,546.12	5,513,311.70	0.3%
Зээлийн тоо Үүнээс:	954	940	-1.5%
Иргэн	953	939	-1.5%
Хуулийн этгээд	1	1	0.0%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	23,583,449,996.00	23,248,759,996.00	-1.4%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.00%	-
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс:	-	354,631,718.83*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	340,071,360.20	-
Хүүгийн төлбөр	-	14,375,851.14	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	184,507.49	-
Хаагдсан зээлийн тоо	-	14	-

\*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2022 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 354.63 сая төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

2022 оны эцсийн байдлаар “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 1.02 сая төгрөг байна.

“Юнайтед Айр Файнэнс” ХХК нь “Бичил Эй Би Эс Актив ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

### 3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бичил Эй Би Эс актив ТЗК” ХХК-ийг “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бичил Глобус Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн хурлын ХЭХ-22/23а/04 тоот шийдвэрээр С.Отгонбат, Ц.Азбаяр, Б.Баасандорж нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Ц.Азбаярыг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 5 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд Үүнд:

#### Хүснэгт 4. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2022.07.05	ТУЗ-ийн даргын сонгох. ХБҮЦ гаргах төсөлд оролцох зөвлөхүүдийг сонгох, журам батлах тухай.	ТУЗ-ийн даргаар Ц.Азбаярыг сонгов. Зээлийн багцын шинжилгээ гаргагчаар “Онч Аудит” ХХК, Санхүүгийн тайланд аудит хийх байгууллагаар “Ниямазон аудит” ХХК Хөндлөнгийн аудитор сонгох, солих тухай журмыг батлав.
2	2022.09.26	Үнэт цаасны данс нээх болон захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтныг томилох тухай Арилжааны банкинд данс нээх тухай	Андеррайтераар дамжуулан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данс нээлгэж захиран зарцуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов. ХХБ холбогдох дансыг нээв.
3	2022.09.27	1. ХБҮЦ гаргах тухай 2. Дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө болон Үнэт цаасны танилцуулга батлах тухай 3. Хөрөнгийн багц худалдан авах, багцад тавих шалгуур үзүүлэлтийг батлах тухай 4. Оролцогч талуудтай байгуулах гэрээний төсөл 5. Журам батлах тухай	1. Нийтэд нээлттэй арилжаалах 10 тэрбум төгрөгийн ХБҮЦ ерөнхий нөхцөлийг батлав. 2. Дунд хугацааны төлөвлөгөө, үнэт цаасны танилцуулгыг тус тус батлав. 3. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлтийг баталж хөрөнгө худалдан авах, фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээг тус тус батлав. 4. Оролцогч талуудтай байгуулах гэрээг батлав. 5. Үйл ажиллагаанд дагаж мөрдөх 8 журмыг төслийг тус тус батлав.
4	2022.09.28	Сонирхолын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэл батлах, зөвшөөрөл олгох тухай	ХБҮЦ гаргах хэлцлийн хүрээнд хийгдэх их хэмжээний сонирхолын зөрчилтэй 5 гэрээ баталж гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
5	2022.12.28	Үйл ажиллагааны зардлыг төсвийг батлах тухай	Компанийн үйл үйл ажиллагааны зардлыг баталж холбогдох зардлыг гаргахыг ХИУ-д зөвшөөрөв.